

“ХОРГО ХАЙРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

№ 2

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”- ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хорго хайрхан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4-р сарын 25-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамжинд байрлах “Монгол Даатгал” ХХК-ийн 3 давхарын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
 - 2.2. Ногдол ашгийн хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний үндэслэлийг танилцуулах;
 - 2.3. ТУЗ-ийн шинэ гишүүдийг сонгох
 - 2.4. Компанийг нэгтгэх журам, төсөл нэмэлт өөрчлөлт оруулах тухай ;
 - 2.5. 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарим шийдвэрийг баталгаажуулах тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 сарын 09-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-д хүргүүлэх өдрийг 2019 оны 3 дугаар сарын 15-ний өдрөөр байхыг тогтоосугай.
5. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах өдрийг 2019 оны 3 дугаар сарын 18-ний өдрөөр, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын 2-оос доошгүй сонинд 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр болон 2019 оны 04 дүгээр сарын 05-ний өдрүүд байхаар 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио,

телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр 2019 оны 03 дугаар сарын 2 ний өдрөөс эхлэн бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

6.2.Хурлын санал хураах хуудас;

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

6.4.Хурлын зар

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг энэхүү Тогтоолын Хавсралт №1, Хурлын зарыг Хавсралт №2, Санал авах хуудасыг Хавсралт №3, Хурлын дэгийг Хавсралт №4-өөр тус тус баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 15.00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурал даргалахыг Б.Аюуш-т даалгасугай.

10. Хурал зохион байгуулах комиссын даргаар Ч.Энх-Амгалан, комиссын гишүүнээр Гендекс ҮЦК -г томилсугай.

11. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: Э.Төгөлдөр /"Гендекс ҮЦК" ХХК/

Гишүүн: Д.Сайнбаяр /"Гендекс ҮЦК" ХХК/

12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлын тэмдэглэлийг үнэн зөв бөгөөд хугацаанд нь бэлэн болгож, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комиссын дарга Ч.Энх-Амгалан даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

